



Дундговь Аймгийн
Гэр бүл, хуухад, залуучуудын
хөгжлийн газар

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 20 одор

Дугаар A/65

Мандалговь

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2, газрын даргын 2020 оны А/33 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын 2020 оны III улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг үнэлэн 2020 оны IV улирлын ур чадварын нэмэгдлийг хавсралтаар олгосугай.

2. Байгууллагын албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг хавсралтад заасны дагуу тооцож олгохыг газрын нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн, хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэн, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

431190181